



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-12
<hr/>	
1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа	5-12

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
03 дугаар сарын 17-ны өдөр /Даваа гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 74 гишүүн хүрэлцэн ирж, 58.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баясгалан, Д.Бум-Очир, Ж.Ганбаатар, Ж.Золжаргал, Б.Тулга;

Чөлөөтэй: С.Амарсайхан;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Э.Одбаяр, Ж.Чинбүрэн;

Тасалсан: Т.Аубакир, С.Ганбаатар;

Хоцорсон: М.Бадамсүрэн-19 минут, О.Батнайрамдал-05 минут, Б.Бат-Эрдэнэ-05 минут, Л.Гантөмөр-08 минут, Х.Ганхуяг-19 минут, Ц.Даваасүрэн-24 минут, Д.Жаргалсайхан-26 минут, П.Мөнхтулга-11 минут.

Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа

Танхимын баруун хойд талд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж;

Зүүн хойд талд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт;

Зүүн урд талд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Дэд дарга Ү.Амарбат, Э.Лхагва, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Менежментийн газрын дарга Т.Нармандах, Хэвлэл мэдээллийн газрын дарга Э.Болортуяа, Иргэд, олон нийттэй харилцах газрын дарга Х.Мөнхбилэг, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Д.Бумдарь, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул;

Урд талд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан, Монгол Улсын Ерөнхий прокурор Б.Жаргалсайхан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга А.Бямбажаргал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга

Б.Солонгоо, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид;

Баруун урд талд Монгол Улсын Их Хурлын даргын зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Т.Төрболд, Монгол Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын зөвлөх Д.Энхбат, Б.Батзаяа нар суудлаа эзэлсэн байв.

Танхимын дээд давхарт Монгол Улсад суугаа гадаад орнуудын элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын төлөөлөгчид суудлаа эзэлсэн байв.

Танхимын баруун хойд, зүүн хойд болон урд хэсэгт байрлуулсан дэлгэц дээр “Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы нээлт. 2025.03.17” гэсэн үг гарч байв.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаанд Монгол Улсын Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ оролцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганыг нээж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэхэд Улсын Их Хурлын гишүүд болон нээлтийн ажиллагаанд оролцогсод босож хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэв.

Нээлтийн ажиллагаа 10 цаг 22 минутад өндөрлөв.

Хоёр.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээлэл /хаалттай/

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан 10 цаг 22 минутаас хаалттай горимоор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээллийг хэлэлцэж, 12 цаг 00 минутад нээлттэй горимд шилжин хуралдаан өндөрлөв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нээлтийн ажиллагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн газрын Иргэд, олон нийттэй харилцах газрын студи, “Монгол кино” нэгтгэл, Tac.mn, Reelnews, News.mn, Subeedei.mn, GoGo.mn, MPA, Tsenzuur.mn, Arslan.mn, “МОНЦАМЭ” агентлаг, iToim.mn, Eguur.mn, “Зууны мэдээ” сонин зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагын болон Улсын Их Хурал дахь Монгол Ардын нам, Ардчилсан намын бүлгүүдийн, мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын, Монгол Улсын Ерөнхий сайдын Ажлын албаны, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэлийн албаны зураглаач, гэрэл зурагчид сурвалжлав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн референт Б.Нарантуяа, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Нээлттэй хуралдаан 22 минут, хаалттай хуралдаан 1 цаг 38 минут үргэлжилж, 126 гишүүнээс 115 гишүүн хүрэлцэн ирж, 91.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

*2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр, Даваа гараг
Төрийн ордон “Их хуралдай”
танхим
10 цаг 00 минут*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Гишүүд суудалдаа суугаад хурууны хээгээ уншуулъя. Улсын Их Хурлын гишүүдийн ирц хүрсэн байна.

Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы нээлтийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын Ерөнхий прокурор, Засгийн газрын гишүүд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга, Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагууд зэрэг төрийн өндөр албан тушаалтнууд, Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газруудын тэргүүн нар оролцож байна .

Эрхэм хүндэт ард иргэд ээ, эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхий сайд аа, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, хүндэт зочид оо,

Монгол түмэн өвлийг өнтэй давж, урин хавартай золгосон энэ өдрүүдэд намрын чуулганы завсарлага тохиож, Улсын Их Хурлын гишүүд иргэд, сонгогчидтой уулзах, хуулийн хэрэгжилттэй бодит байдалд нь танилцах, ажлын хэсгүүд хэлэлцүүлэг зохион байгуулах, туршлага судлах зэрэг олон ажлууд өрнөлөө.

Төлөөлөл өргөжиж 126 гишүүнтэй болсон парламентын энэ танхимд гишүүд та бүхнээр дамжин иргэдийн дуу хоолой илүү өргөн хүрээнд тогтмол сонсогдож байгаасай гэж хүсэж байна. Албан өрөөний цонхоор асуудлыг харж шийдэх, бодит нөхцөлийг таньж, мэдэх шийдэл олохын ялгаа их ээ. Мөн олон түмний нэрийг баривч цөөн хэдэн хүний хүсэл далд шургалсан цахим сүлжээгээр өнөөдрийн Монголын амьдрал, хөгжил хэмжигдэх учиргүй ээ.

Улсын Их Хурлын гишүүд завсарлагын хугацаанд иргэд, байгууллагуудтай нүүр тулан уулзаж, нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, асуудлын гүн рүү орж, санаа оноогоо хуваалцаад ирсэн нь энэ хаврын чуулганы хууль тогтоомжийн төслүүдэд хэлэлцүүлэг, ажил хэрэгч бүтээлч өрнөхөд нөлөөлөх нь гарцаагүй ээ. Чуулгын завсарлагааны хугацаанд миний бие Улсын Их Хурлын гишүүдийн хамтаар хангайн, баруун, төвийн, зүүн, говийн бүсийн аймгуудад ажиллаж, малчид, хоршоологчид, худалдаа, бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчид,

хуульчид, ахлах ангийн сурагчдын төлөөлөл зэрэг 25 мянга гаруй иргэдтэй уулзлаа.

Иргэд биднээс бүрэн эрхийн хүрээ хязгаар, боломжоос хальж давсан зүйлийг хүсэхээс илүүтэй парламент нь парламент шиг ажиллахыг хэлж, сануулж байна. Иргэдээ ажил, орлоготой байлгах, үр хүүхдүүдээ орчин нөхцөл хангагдсан сургууль, цэцэрлэгт хамрагдуулах, эрүүл мэндийн үйлчилгээ ойр байх, зам харгуй, дэд бүтцийг хөгжүүлэх гээд наад захын амин чухал зүйлсийг хөндөн үүргээ, үгээ дайж байна. Энэ бол та бидний баталж буй хуулиуд иргэдийн амьдралын чанарыг ахиулахад чиглэх ёстой гэсэн үг юм.

Хот, хөдөөгийн амьдралын чанарын ялгаа орших ёсгүй ээ. Хот, хөдөө хамтдаа хөгжих нь нийгмийн эрх тэгш, аюулгүй, тогтвортой байдлын суурь мөн. Гэвч эрүүл мэнд, боловсролын хүртээмж, худалдаа, дэд бүтэц, бизнес эрхлэх боломж, нөхцөл ялгаатай хэвээр байна.

Тиймээс энэ асуудал хууль, төсвийн бодлогын эрэмбийн эхэнд байвал зохино. Малчид орон нутгийн бизнес эрхлэгчид хөдөлмөрийн үр шимээрээ чинээлэг амьдрах бололцоо байна. Гагцхүү хөрөнгө оруулалт, өртөг багатай санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал байна. Ийм нөхцөлд хөдөөгийн бизнес эрхлэгчийг бүх шатад эрвийх дэрвийхээрээ дэмжих ёстойг энд онцлон тэмдэглэе.

Иргэд, малчдын санаачилгаар эхэлж байгаа өрхийн хоршооны үйлдвэрлэл, бүс нутаг цаашлаад улс даяар төдийгүй гадаад зах зээлд нэвтрэхэд хөнгөн үйлдвэр, технологийн паркууд ихээхэн үүрэг гүйцэтгэхээр байна. Улсын Их Хурал одоогоос 23 жилийн өмнө үйлдвэр, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл баталж, 10 парк байгуулахаар шийдвэрлэж байсан боловч харамсалтай нь өнөөдөр ажил хэрэг болоогүй.

Тиймээс Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд байгуулагдах хөнгөн болон хүнд үйлдвэрийн паркууд бодитоор бий болоход Аж үйлдвэржилтийн байнгын хороо анхаарч, Улсын Их Хурлын холбогдох тогтоолын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах хэрэгтэй.

Үйлдвэрлэл, бизнестэй зэрэгцэн анхаарлын төвд байх асуудлын нэг бол тэгш хүртээмжтэй боловсрол. Боловсролын хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж, аймаг, сумын ахлах ангийн сурагчидтай уулзахад хүүхдүүдийн үг нүүр түлэм халуун, бас үнэн байсныг хэлэх нь хэрэгтэй. Олон мянган сурагчидтай уулзахад бидний ирээдүй болсон хүүхдүүд сурах, мэдэх эрмэлзэл дүүрэн байгаа нь бахархалтай.

Гэвч тэдний төлөө бидний хийх ажил их байна. Мэргэжлийн багш хүрэлцээгүй, цахим хичээлийн зохион байгуулалт дулимаг, интернэтийн хурд муу, номын сангийн багтаамж бага, хүйтэн сургуулийн орчин зэрэг та бидний шийдэх асуудал мөн.

Нийслэл, суурин газарт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, тэр дундаа стандартын асуудлууд хурцадмал болсон. Хотын дэд бүтцийн төлөвлөлт, иргэдийн таатай амьдрах орчныг бий болгоход чиглэсэн оновчтой, зөв байх учиртай. Гэр хорооллыг барилгажуулахад эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний

хүртээмжийг оновчтой төлөвлөж, шинийг нэвтрүүлэхтэй зэрэгцэн хуримтлагдсан олон асуудлыг шийдвэрлэхэд нийслэлийн төлөвлөлт чиглэх ёстой. Хотын тулгамдсан асуудлыг захиргааны аргаар шийдэхдээ Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгийн бага хөндөх тэрхүү хувилбарыг сонгохыг орон нутгийн иргэд сануулж байсныг анхааралдаа авахыг хүсье.

Ер нь аливаа хурсан асуудлыг цаашид захиргааны бус, харин оролцоо, зөвшилцлийн аргаар шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдүүлэхийг нэн тэргүүнд дэмжин ажиллана.

Монгол Улсын Засгийн газар, аймаг, нийслэлийн удирдлагууд хамтран бүсчилсэн хөгжлийн бодлого, үзэл баримтлалын хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн албаны хүний нөөцийн бодлогыг тодорхойлж бэлтгэхэд нэн тэргүүнд засаг захиргаа, төрийн байгууллагын оновчтой бүтэц зохион байгуулалтыг хийж, тулгамдсан асуудлаа ярилцаж шийдвэрлэх, хөдөөгөөс хот руу чиглэх урсгалыг хотоос хөдөө орон нутаг руу чиглүүлэх хөдөөгийн сэргэлтийг идэвхжүүлэх шаардлагатай хуулийн төсөл, арга хэмжээнүүдийг энэ хаврын чуулганаар боловсруулан хэлэлцүүлж, бүсийн тогтвортой хөгжлийг бий болгоход анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Улсын Их Хурлын даргын 77 дугаар захирамжаар байгуулагдсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, шаардлагатай хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын хэсэг үйл ажиллагаагаа эрчимжүүлж, энэ хаврын чуулганаар хэлэлцүүлэх шаардлагатай байгааг анхааруулан хэлье.

Эрхэм гишүүд ээ,

Бидэнд хэлэлцэж шийдэх ажил их байна. Хаврын ээлжит чуулганы хугацаанд нийгмийн өмнө тулгамдсан асуудлын нөхцөл, шалтгааныг нарийвчлан авч үзэж, ул үндэстэй шийдвэрлэх асуудлыг шилээ даран хүлээж байна.

Нэгдүгээрт, Улсын Их Хурал мега төслүүдийг хэрэгжих эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд онцгой анхаарч, улс орныхоо хөгжил, дэвшлийн төлөө хамтарсан засгийн газраа бүрэн дэмжиж ажиллах нь зүйтэй.

Геополитик, эдийн засгийн харилцааны эгзэгтэй энэ цаг үед Улсын Их Хурал төрийн эрх барих дээд байгууллагын хувьд төрийн бодлогын тогтвортой байдал, тууштай хэрэгжилтийн зарчмыг баримталж, үндэсний эв нэгдэл, гадаад бодлогын тогтвортой байдал, институц хоорондын үйл ажиллагаа, уялдаа холбоог дэмжиж, төрийн үйл ажиллагааны салаа мөчир бүрд зөв хандлагыг харуулах шаардлагатай байна.

Улсын Их Хурлын энэ бүрэлдэхүүн баталсан анхны чухал шийдвэрүүдийн нэг бол “Засгийн газрын үйл ажиллагааны 2024-28 оны хөтөлбөр” Засгийн газар юунд төвлөрч, ямар үр дүнд зорьж, яаж ажиллахыг бид батлаад ердөө 6 сарын нүүр үзэж байна.

Улс төржилт, намчирхал, талцал, хуваагдал гэхээс илүү шинэ тогтолцоогоор бүрдсэн 126 гишүүнтэй парламент улс орны хөгжлийг хурдасгах шийдвэрүүд гаргах нь түүхэн үүрэг байна.

Парламент хоорондын найрсаг хамтын ажиллагааг идэвхжүүлэх, харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр гадаад улсын төрийн удирдлага, Элчин сайд нартай хийсэн уулзалтаар Монгол Улсын хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт тогтвортой, урт хугацаанд хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлж байна.

Тиймээс алсын замд дөрөө нийлэх, хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээхэд илүү хариуцлагатай байх цаг үе ирснийг тэмдэглэн хэлье.

Хоёрдугаарт, Хүн төвтэй хууль зүйн бодлогын суурь Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тавигдах ёстой. Хууль бүтээх сэтгэлгээг өөрчлөхгүйгээр эрх зүйн хөгжилд хүрэх боломжгүй. Хуулийн төвд хүн орших учиртай. Хууль хэнийг ч үл ялгаж, эрх тэгш хэрэгжиж, хууль дээдлэх ёс бүрэн тогтох ёстой.

Гэтэл өнөөдөр хууль ба журмын зохист харилцаа алдагдсаны улмаас хууль биш харин журам ноёлж байна. Албан тушаалтны үзэмжээр хандах, авлига, хүнд суртал, газар авах хөрс болж байгаа журмуудыг үндсээр нь устгаж, хууль дээдлэх зарчмыг бодит утгаар хэрэгжүүлэх цаг нэгэнт иржээ.

Тиймээс Хууль зүйн байнгын хорооны даргаар ахлуулсан ажлын хэсгээс боловсруулж, өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан журмыг дураар, үзэмжээр батлах явдлыг таслан зогсоох, журам батлах эрх олгож буй хуулийн заалтуудад өндөр шалгуур тавих эрх зүйн орчныг энэ хаврын чуулганаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Ингэснээр шинэ харилцааг журмаар зохицуулдаггүй байх шаардлага тавигдаж, журмыг зөвхөн хуульд заасан тохиолдолд, мөн хуулиар тогтоосон хүрээ хязгаарт баталдаг болж, журмаар зохицуулж үл болох буюу зөвхөн хуульд тусгах харилцааны зааг тодорхой болно.

Түүнчлэн хүн төвтэй үзэл баримтлалд тулгуурлан хуулийн төслийн хүний эрхийн нийцлийг тодорхой аргачлалаар үнэлдэг тогтолцоо нэвтэрч, хуулийн төслөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд тавигдах шаардлагыг тодорхой зохицуулна.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдахтай холбогдуулан журам буюу захиргааны хэм хэмжээний актуудыг хуульд нийцүүлэх зорилгоор холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах, хуулийн төслийг өргөн мэдүүлэх болон санал боловсруулах ажлыг Засгийн газар болон Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагууд эхлэх учиртайг онцлон тэмдэглэе.

Гуравдугаарт, Зах зээлийн шударга өрсөлдөөн, эдийн засгийн тэлэлтийн эрх зүйн орчныг дэмжих хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэхэд анхаарал хандуулна. Эрх бүл иргэн чинээлэг бол улс орон чинээлэг гэдэгтэй та бүхэн санал

нийлэх биз ээ. Чинээлэг иргэд, малчид, хувийн хэвшил бий болох, өсөн дэвжих зах зээлийн эрүүл тогтолцоо үгүйлэгдэж байна. Худалдаа бизнест том нь жижгээ шахаж эзэгнэх давамгайл байдалтай нь хүч түрэх үзэгдэл газар авч байна. Өрсөлдөөний тухай хуульд компаниудын энэ мэт зүй бус авирыг хязгаарлаж, захиргааны болон санхүүгийн хариуцлага ноогдуулах заалт байгаа хэдий ч хариуцлага үр нөлөөтэй байх зарчим алдагдсан байна.

Монополтой холбоотой асуудлаар холбогдох байгууллага зөрчлийн шийдвэр гаргадаг ч тухайн цаг үеэсээ бүр хойно шүүхийн замаар шийдэгдэж байгаа нь үр нөлөө, ач холбогдол өгөхгүй байна.

Зүй ёсны монопол байдалтай аж ахуй эрхлэгчийн үнийн өөрчлөлтийг зах зээлийн харилцааны зөнд нь үлдээснээс хэрэглэгчдийн эрхийг хамгаалалтгүй орхижээ. Монополын хяналтыг хязгаарласны улмаас өнөөдөр 133 зүй ёсны монопол байгууллага байгаагаас зөвхөн 13 нь монополын эсрэг газрын эрхлэх асуудалд хамаарч, үлдсэн монополуудын хувьд хяналт алга байна. Үүнээс шалтгаалж суурь бараа, бүтээгдэхүүний бүрдүүлэгч монопол салбаруудад монополын хяналт шүдгүй арслан мэт болсон. Монопол, өрсөлдөөний ухаалаг бус зохицуулалт эцсийн дүндээ үнэ өсөх, хөөрөгдөх бас нэг хүчин зүйл болж байгаа тул энэ салбарын эрх зүйн орчны шинэчлэлийг хийнэ.

Эдгээр нөхцөл байдал нь 2003 онд батлагдсан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг үнэлж, орчин цагийн хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг хойшлуулалгүй эргэн харах шаардлагыг зүй ёсоор бий болгож байна. Хэрэглэгчийн гар дээр очих бараа, бүтээгдэхүүний үнэ тодорхойлоход цахилгаан, дулааны тариф чухал нөлөөтэй. Цахилгааны үнийн хэрэглээний түвшнээр нэмэхдээ халаалтаа цахилгаанаар шийдсэн иргэдэд төлбөрийн их дарамт үүссэнийг иргэдийн зүгээс эргэн харах хүсэлт гаргаснаар Засгийн газар иргэдийн санал, гомдолд шуурхай хандаж, шөнийн халаалтын хөнгөлөлтийг илүү өргөжүүлсэн арга хэмжээг аваад байна. Цаашид эрчим хүчний салбарын эрх зүйн шинэчлэлийн ажил хаврын чуулганы чухал хэсэг байх болно.

Өнөөдөр дулаан, цахилгаан гэсэн 2 том салбарын харилцааг Эрчим хүчний тухай нэг хуулиар зохицуулсны зэрэгцээ тухайн хууль нь хэт товч, ерөнхий учраас энэ салбар хуулиар биш харин 800 гаруй дүрэм, журмаар зохицуулагдаж байгаа нь жинхэнэ гажуудал мөн юм.

Иймд хууль иж бүрэн зохицуулалттай, ойлгомжтой байх бодлогын хүрээнд цахилгаан, дулааны иж бүрэн, бие даасан зохицуулалттай хуультай болох шаардлагатай.

Ингэхдээ цахилгааны салбарт өрсөлдөөнт зах зээлийн загварыг нэвтрүүлж, салбар дахь төрийн оролцоог зохист түвшинд барих, өрсөлдөөн нь цахилгааны үнэ тариф, өртөг, зардал бууруулах болон инновац, шинэ технологи нэвтрүүлэхэд чиглэдэг байх нь чухал юм. Эрчим хүчний салбарын өрсөлдөөнт тогтолцоо нэвтрүүлэх нь дотоодын аж ахуй эрхлэгчид цаашид цахилгаан экспортлох боломж бүрдүүлэх эерэг суурь болох ёстой.

Чуулганы завсарлагааны хугацаанд татварын багц хуулийн хэрэгжилттэй танилцах, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах

ажлын хэсэг холбогдох яам, байгууллагуудтай хамтран оролцогч талуудыг хамруулан олон хэлэлцүүлгийг зохион байгуулж ажилласан.

Хөрөнгө оруулагчдын зүгээс улс төрийн тогтворгүй байдал, таамаглах боломжгүй татварын орчин, өндөр татвар нь хөрөнгө оруулалт хийх сонирхол төрүүлэхгүй байгааг шүүмжилдэг.

Татварын тогтвортой орчныг зохицуулсан хуулиуд хэрэгжихгүйгээс тодорхойгүй байдал үүсдэг. Жижиг үнэлгээнд суурилсан давхар ноогдуулдаг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, уул уурхайн ашиглалтын өмнөх үйл ажиллагаанд гарсан худалдан авалтын нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгодоггүй, татвар хураах, маргаан шийдвэрлэх явцад гардаг үл ойлголцол зэрэг зохион байгуулалтын шинжтэй асуудлаас болж хөрөнгө оруулагчид үргэх учиргүй ээ.

Одоо үйлчилж байгаа татварын шатлалыг өнөөгийн эдийн засаг, бизнесийн харилцааны онцлог, нөхцөл байдалд уялдуулах, жижиг, дунд, том бизнес хамтдаа зэрэгцэн өргөжин тэлэх таатай нөхцөл бүрдүүлэхэд анхаарч, татварын эрх зүйн шинэчлэл хийх нь чухал юм. Мөн хэт өндөр байгаа зарим төрлийн татварын хувь, хэмжээг олон улсын түвшинд хүртэл бууруулах хэрэгтэй. Үндэсний аж ахуйн нэгжүүдэд татварын дарамт үүсэж, өсөж хөгжихөд саад болж буй хуулийн хийдлийг нэн даруй судалж, иргэд аж ахуйн нэгжид ээлтэй шийдвэрүүдийг гаргах нь та бидний үүрэг юм.

Ер нь салбарын хууль тогтоомжийн хүрээнд Улсын Их Хурал нэгэнт шийдвэрлэсэн хөрөнгө оруулалтын асуудлыг эргэн харах шаардлага үүсэх тохиолдолд салбарын хууль тогтоомжийн суурь, нийтлэг тулгамдсан асуудлыг цогцоор нь харж, боловсронгуй болгосны үндсэн дээр хэлэлцэх нь ирээдүйд тогтвортой хэрэгжих үндэс нь болно. Ойрын ирээдүйд их бүтээн байгуулалт, мега төслүүдийг эрчимтэй эхлүүлж, хувийн хэвшлийг тэлэх бодлого барьж буй энэ цаг үед нэн тэргүүнд стандартын орчныг ойлгомжтой, тодорхой болгож цаашид стандартыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх зайлшгүй шаардлагатай.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид стандартыг боловсруулах, хэрэгжүүлэх, мөрдүүлэх, хяналт тавих талуудын харилцаа, хариуцлагын механизм дутмаг, тодорхойгүй байдал, ойлголтын зөрүү их байна. Монгол Улсын хэмжээнд 6689 стандартын хэрэгжилт санасан түвшин, хүлээлтэд нийцэхгүй байна.

Иймд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хаврын чуулганаар хэлэлцэх нь зүйтэй.

Энэ хаврын ээлжит чуулганаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэл, 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, хөгжлийн төлөвлөгөө, 2027-28 оны төсвийн төсөөлөл, Засгийн газрын өрийн удирдлагын 2026-28 оны стратегийн баримт бичиг зэрэг улс орны төсөв, санхүүгийн чухал хууль тогтоомжийг хэлэлцэн батална.

Уг хууль тогтоомжийг тогтоосон хугацаанд хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах талаар Байнгын хороод, холбогдох байгууллага анхаарч ажиллах ёстой.

Эрхэм гишүүд ээ,

Улс орны эдийн засагт дунд болон урт хугацаандаа эерэг өөрчлөлт авчрах бодлогын зоримог шийдлүүд, том төслүүд, тэдгээрийн эдийн засагт үзүүлэх үр дагаврыг өнөөдрийн үүсээд байгаа гадаад орчны нөхцөл байдалтай уялдуулж, эдийн засагт дарамт болохгүйгээр ард иргэдийн амьжиргаанд ахицтай байхыг зорьж ажиллахыг Засгийн газраас шаардах, биелэлтэд анхаарч ажиллах нь Улсын Их Хурлын үүрэг юм.

2024 оны жилийн эцсийн эдийн засгийн өсөлт нь 4.9 хувьтай, инфляц 9.2 хувьтай, төсвийн тэнцэл (-1) хувьтай, төлбөрийн тэнцэл 622 сая ам.долларын ашигтай, гадаад валютын нөөц 5.5 тэрбум доллартой гарсан. Харин энэ хоёрдугаар сарын эцсээр инфляц 9.6 хувьтай, гадаад худалдааны тэнцэл 294 сая ам.долларын ашигтай, гадаад валютын нөөц 4.4 тэрбум ам.доллар буюу валютын төлбөртэй барааны 4.5 орчим сарын импортыг хангах түвшинд хүрсэн. Экспортын гол түүхий эд болох нүүрсний үнэ бидний төсөөлж байснаас өндөр хувиар буурч, нэгдүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр төсвийн орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 38.9 хувиар бага төвлөрч, төсвийн тэнцэл 493 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. 2024 оны нэгдүгээр сард төсөвт 676 тэрбум төгрөгийн ашигтай гарч байсан.

Иймд цаашид сэргэж эхэлж байсан эдийн засгийн идэвхжилтийг хадгалах нь үүсээд байгаа орчин нөхцөлд юу юунаас илүү чухал болоод байна. Гадаад орчны хүчин зүйлээс нөхцөлдсөн эмзэг байдлаас гарахын тулд дотоодын эдийн засгийн бүтцийг өөрчилж, дотоодын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих хэрэгтэй. Иргэд ээ ирээдүйд улс орны эдийн засгийг олон суурьт, илүү төрөлжсөн бүтэц рүү шилжүүлэхэд хэрэгтэй арга хэмжээнүүдийг, тэр дотроо бидний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудыг хэрхэвч орхигдуулж болохгүй ээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны 14 дүгээр тогтоолоор хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаврыг баталсан. Энэ хүрээнд 10 гаруй хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах, хууль тогтоомжийн үр дагаварт үнэлгээ хийх, 16 тайлан, илтгэл, мэдээллийг сонсох, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгдсэн тайлан зэрэг асуудлыг хэлэлцэхээр тогтсон. Үүний зэрэгцээ хуульд заасны дагуу Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асуух, асуулга тавих, тулгамдсан асуудлаар хяналтын сонсгол хийх, хянан шалгах түр хороо байгуулж, тусгай шалгалт явуулж, тэдгээрийг хэлэлцэж, үр дүнг нь тооцож ажиллана.

Нэг талаас Улсын Их Хурлын гишүүдийн үр дүнтэй оролцоо, ирцийг сайжруулах шаардлагатай байгааг иргэд, сонгогчид хатуу шүүмжилж байна.

Тиймээс иргэдийн төлөөлөл болж сонгогдсон гишүүд өргөсөн тангарагтаа үнэнч байж, хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэх ёстой. Улсын Их Хурлын даргын хувьд гишүүдийн ирцийг тогтмол мэдээлж, иргэд, сонгогчидтой эргэх холбоог сайжруулах ажил, арга хэмжээг дэмжиж ажиллах болно.

Эрхэм гишүүд ээ,

Энэ удаагийн Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлээд 250 гаруй хонож байна. Улс орныхоо хөгжил дэвшлийг урагшлуулах, ард иргэдийн амьдралын чанарыг сайжруулах талаар парламентад суудалтай нам, эвслийн амлалт, мөрийн хөтөлбөрт тодорхой зорилтууд байгаа.

Бид бүхэн 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа урьдчилан төлөвлөж, хүрэх үр дүнгээ тодорхойлон стратеги төлөвлөгөөгөө баталсан. Төлөөллийн байгууллагын хувьд үйл ажиллагаагаа ил тод, хариуцлагатай, үр дүнд чиглэсэн байдлаар явуулж, үр дүнг тайлагнаж ажиллах ёстой.

Хаврын чуулганаар хийх ажил, хэлэлцэх асуудлын дийлэнх хэсгийг хууль тогтоомжийг судалж, боловсронгуй болгох, хянан шалгах зэрэг тодорхой асуудлаар Улсын Их Хурлаас байгуулагдан ажиллаж байгаа ажлын хэсгүүдийн судалж боловсруулсан хууль тогтоомжийн төсөл бүрдүүлэх тул ажлаа эрчимжүүлж, тогтоосон хугацаанд холбогдох баримт бичиг, шийдвэрийн төслөө танилцуулж ажиллахыг тусгайлан анхааруулъя.

Улс орныхоо язгуур эрх ашгийг эрхэмлэн ард түмнийхээ итгэл найдварыг биелүүлж, Монгол Улсын хөгжил дэвшлийн төлөө хууль тогтоох хэрэгт хамтдаа хичээнгүйлэн ажиллаж чадна гэдэгт итгэл дүүрэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулган нээснийг мэдэгдье.

Ингээд Улсын Их Хурлын 2025 оны ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье.

Одоо Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээллийг нэгдсэн хуралдаанаар сонсоно.

Чуулганы нэгдсэн хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлье.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

10.22 цаг

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан хуралдааныг хаалттай горимоос нээлтэй горимд шилжүүлж, хуралдаан өндөрлөснийг мэдэгдэж, алх цохив.

12.00 цаг

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Д.ОТГОНДЭЛГЭР

